

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Засгийн газрын яамд, агентлагуудтай
хийсэн зөвлөлдөх уулзалт
2017 оны 8-р сарын 30

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 8 дугаар сарын 30-нд Засгийн газрын яамд, агентлагуудын 33 төлөөлөгчтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
---------	-------------------

<p>Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)</p>	<p><u>Сорилт, бэрхшээл:</u></p> <p>Эдийн засгийн бодлого, өсөлт:</p> <ul style="list-style-type: none"> • Эдийн засаг уул уурхайгаас хараат, өсөлт тогтворгүй, уул уурхайн бус салбаруудын хөгжил сул, эдийн засаг тогтмол савладаг, засаглал сул бөгөөд банк, санхүүгийн салбар эмзэг байдалтай. • Хүртээмжтэй өсөлтийг хангах шаардлагатай бөгөөд үүний тулд боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах хэрэгтэй. <p>Засаглал, хариуцлага, төрийн алба:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн алба тогтворгүй ба улс төрийн мөчлөг даган солигддогос төрийн албаны чадавх сул байдаг. Төрийн албанд мэдлэг, чадвартай албан хаагчдыг авч үлдэх шаардлагатай. Авлигал, хариуцлагын сул тогтолцоо болон төрийн албан дахь улс төрийн оролцоо өндөр. • Төрийн бодлого тууштай хэрэгждэггүй бөгөөд төр засгийн бүх шатанд уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй. Урт хугацааны хөгжлийн бодлого байгаа боловч дунд хугацааны бодлого төлөвлөлт, стратеги хангалттай байдаггүй. • Төрийн байгууллагуудын судалгаа, бодлогын шинжилгээ хийх чадвар сул байдаг тул мэдлэг, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах явцыг хөгжүүлэх шаардлага байна. Бодлогын төлөвлөлтийн чадавх, арга хэрэгсэл байдаггүй. • Газар нутгаас шалтгаалсан хүн амын тэнцвэргүй байдал үүссэн, жишээ нь ахмад настнууд орон нутагт давамгайл байна. <p>Байгаль орчин:</p> <ul style="list-style-type: none"> • Монголд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөс улбаалж ган гачиг, үер, зуд, бэлчээрийн талхлал болон хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн ихсэн зэрэг үзэгдэл ихэсч байна. • Орчны бохирдол болон бусад хот, суурин газруудын бусад асуудал хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөнөөс үүсч байна. <p><u>Боломж болон хамтын ажиллагааны чиглэлүүд:</u></p> <p>Хөдөөгийн хөгжил:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөөгийн хөгжлийн цогц бодлогыг боловсруулах • Хөдөөгийн хөгжлийн дэмжин, хөдөө орон нутаг дахь ядуурлыг бууруулах • Бэлчээр, усны менежмент, хэрэглээг зохицуулах • Хөдөө аж ахуй болон мал аж ахуйд суурилсан хөнгөн үйлдвэрийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх • Хөдөө аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх • Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг дэмжих • Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах
---	---

- Тогтвортой хөгжил болон эрсдэлийн удирдлага гэсэн ойлголтуудыг хамт хөгжүүлэх, авч үзэх шаардлагатай. Гамшгийн эрсдэлийн удирдлага байхгүй бол эдийн засгийн өсөлтийн үр дүнг маш хурдан алдаж болзошгүй.

Санхүү, хөрөнгийн зах зээл

- Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, бэлэн мөнгөний гүйлгээг зохицуулахтай холбоотой бодлогын санал зөвлөмж боловсруулах.

Эдийн засгийн бодлого

- Уул уурхайн бус, ажлын байрыг ихээр бий болгодог салбаруудыг өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.
- Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, аялал жуулчлал, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж, нөөц бололцоог бодолцон эдийн засгийг төрөлжүүлэх бодлогыг боловсруулах.
- Өндөр бүтээмжтэй, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг дэмжих. Импортыг орлох, экспортод чиглэсэн үйлдвэрлэлээр дамжуулж эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтой.
- Хувийн хэвшлийг хөгжүүлж, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах.
- Төрийн байгууллагуудын дунд тогтмол, F2F бодлогын хэлэлцүүлгийн арга хэрэгслийг бий болгох.
- Судалгаа шинжилгээ, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах явцыг дэмжих, үүний тулд судалгаа шинжилгээний болон төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх.
- Засгийн газрын мэдээллийн нэгдсэн санг байгуулах, мэдээллийн төвүүдийг байгуулах.
- Хувийн хэвшил ажлын байрыг нэмэгдүүлэхэд их хувь нэмэр болсон.

Хүний хөгжил:

- Хүртээмжтэй өсөлт, хамтын хөгжил цэцэглэлтийг хангах хэрэгтэй.
- Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хамрагдалт, хүртээмжийг сайжруулах хэрэгтэй. Сургуулийн өмнөх боловсрол, хоол тэжээл болон эрүүл мэндэд хөрөнгө оруулснаар үе дамжсан ядуурлаас салах боломжтой.
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж боловсролын тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай.
- Ядуурлыг бууруулахын тулд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ажлын байр, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэн, нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоог сайжруулах хэрэгтэй.
- Ядууст чиглэсэн нийгмийн халамж, ажил эрхлэлтийг дэмжих.
- Олон талт ядуурлыг хэмжих арга зүйг боловсронгуй болгох.
- Уул уурхайн салбараас орж буй орлогыг хүний хөгжил, дэд бүтцийг сайжруулахад зарцуулах.
- Хүн амын насжилтанд бэлтгэх.

Байгаль орчны хамгаалал:

- Байгалийн баялгийн удирдлага, тэр дундаа усны менежментийг сайжруулах.
- Газар хөдлөлт, үер, зуд, ган гачин зэрэг гамшгийн эрсдэлийн менежментийг чадавхийг бэхжүүлэх, жишээ нь сургуулийн барилгуудыг газар хөдлөлтөд тэсвэртэй болгох.
- Байгаль орчны бодлогыг хөгжлийн бодлогын нэг хэсэг болгон авч үзэх.

<p>ДБГ-ын оролцооны талаарх санал зөвлөмж</p>	<p>Арга зам, хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Түрүүчийн Түншлэлийн стратегийн хэрэгжилтийн үед тулгарсан бэрхшээл, сургамжийг эргэн харж, ирээдүйн үйл ажиллагааны үр дүнг тодорхой боловсруулах. • Байгаа нөөц боломжийг улс орон яагаад бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа учир шалтгааныг ойлгож, дүн шинжилгээ хийх. • Түншлэлийн стратегийг улс орны урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээ болох Монголын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 баримт бичигтэй нийцүүлж, Үндэсний хөгжлийн агентлагтай уялдаа холбоотой боловсруулах хэрэгтэй. • Бүх салбарт үйл ажиллагаагаа явуулахын оронд илүү тодорхой, бодитой хэмжигдэхүйц үр дүн гаргахын тулд тодорхой түлхүүр асуудлуудыг сонгон ажиллах. • ДБГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхийн хажуугаар дүн шинжилгээ, техникийн туслалцааны чанарыг хадгалах. • Төсвийн санхүүжилтийн дэмжлэгийг урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулах. • ДБГ-ийн Засгийн газар, хувийн хэвшил болон хөгжлийн түншүүдийг нэг доор цуглуулан, хамтран ажиллахад уялдаа холбоог хангах тал дээр ажиллах.
--	---

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

Боломжит хариулт	Оролцогчдын хариулт
Төрийн удирдлага/шинэтгэл	53.85%
Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	38.46%
Ус, ариун цэврийн байгууламж	38.46%
Боловсрол	38.46%
Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	23.08%
Хөдөөгийн хөгжил	23.08%
Эрүүл мэнд	23.08%
Эрчим хүч	23.08%
Байгалийн нөөцийн удирдлага	15.38%
Бусад	15.38%
Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	15.38%

Боломжит хариулт	Оролцогчдын хариулт
Авлигатай тэмцэх	15.38%
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	15.38%
Эрх тэгш боломжоор хангах	15.38%
Нийгмийн хамгаалал	15.38%
Хүнсний аюулгүй байдал	15.38%
Хотын хөгжил	7.69%
Гамшгийн эрсдэлийн удирдлага	7.69%
Эдийн засгийн өсөлт	7.69%
Гадаадын хөрөнгө оруулалт	0.00%
Зам, тээвэр	0.00%
Худалдаа, экспорт	0.00%
Санхүүгийн зах зээл	0.00%
Хувийн хэвшлийг хөгжүүлэх	0.00%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хүний хөгжлийг дэмжих	84.62%
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	53.85%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	30.77%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	30.77%
Бүгд чухал	30.77%
Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	7.69%